



**НИЙСЛЭЛИЙН
НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/69

Улаанбаатар хот

Хүүхдийн болон ажилчдын автобусыг бүртгэх, чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээгээр зорчих, улсын дугаарын хязгаарлалтаас чөлөөлөх журмыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 213 дугаар тогтоол, Замын хөдөлгөөний дүрмийн 11.10 дах заалт, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1037 дугаар захирамж, 2019 оны А/817 дугаар захирамжаар батлагдсан Нийтийн тээврийн үйлчилгээний газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хүүхдийн болон ажилчдын автобусыг бүртгэх, чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээгээр зорчих, улсын дугаарын хязгаарлалтаас чөлөөлөх журам”-ыг нэгдүгээр, хүүхдийн автобусны зөвшөөрлийн загварыг хоёрдугаар, ажилчдын автобусны зөвшөөрлийн загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталж, 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Хүүхдийн болон ажилчдын автобусыг бүртгэж бүртгэлийн сан үүсгэх, зөвшөөрөл олгож, чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээгээр зорчих тээврийн хэрэгслүүдийн мэдээллийг холбогдох байгууллагуудад тухай бүр хүргүүлэн ажиллахыг Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс /Б.Дөлгөөн/-т, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын хэлтэс /З.Цэвээндорж/-т, автобусыг тогтоосон хугацаанд техникийн хяналтын үзлэгт оруулах ажлыг хуваарийн дагуу зохион байгуулж, шуурхай хийж гүйцэтгэхийг Техникийн хяналтын үзлэгийн төв /Д.Галбадрах/-д тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Нийслэлийн Тээврийн газрын даргын 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/28 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Захиргаа удирдлага, Санхүүгийн хэлтсийн дарга М.Мөнхбаярт үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ


Ч. САЙХАНБАЯР



D:\d disk\alban khereg\Явсан бичиг 2020\TUSHAAL.docx

2117428 1119201715 ГСТ0233

Нийтийн тээврийн үйлчилгээний газрын
даргын 2020 оны 09 дүгээр сарын 28-ны
өдрийн 4/ дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт



ХҮҮХДИЙН БОЛОН АЖИЛЧДЫН АВТОБУСЫГ БҮРТГЭХ, ЧИГЛЭЛИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЭГНЭЭГЭЭР ЗОРЧИХ, УЛСЫН ДУГААРЫН ХЯЗГААРЛАЛТААС ЧӨЛӨӨЛӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэ журмын зорилго нь хүүхдийн болон ажилчдын автобусанд Автотээврийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргах, бүртгэлийн санд бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, тэдгээрийг чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ болон улсын дугаарын хязгаарлалтгүй зорчуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Тээвэрлэгч нь тээвэрлүүлэгч болон эрх бүхий бусад байгууллагатай хүүхэд болон ажилчид тээвэрлэх гэрээ байгуулсан байна.

1.3 Тээвэрлүүлэгч нь авто замын зорчих хэсгийн чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ, автотээврийн хэрэгслийн улсын дугаарын сүүлчийн тоогоор ялган замын хөдөлгөөнд оролцуулахыг хязгаарласан авто замаар хүүхэд болон ажилчид тээвэрлэж, зорчих хүсэлтээ албан бичгээр /Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдээр дамжуулж/ Нийтийн Тээврийн үйлчилгээний газарт холбогдох баримт бичгийн хуулбарын хамт хавсаргаж ирүүлнэ.

1.4 Ирүүлсэн хүсэлтийн дагуу Автотээврийн хяналтын улсын байцаагч “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2011, “Хүүхэд тээвэрлэх автобус. Автобус ба үйлчилгээнд тавих шаардлага” MNS 6440:2014 стандарт болон бусад эрх зүйн бичиг баримтын хүрээнд автотээврийн хэрэгслийн техникийн байдлын дүгнэлтийг ажлын 10 хоногийн дотор гаргана.

1.5 Нийтийн Тээврийн үйлчилгээний газрын Автотээврийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн тус газрын Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс автотээврийн хэрэгслийг бүртгэлийн санд бүртгэж, чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ болон улсын дугаарын хязгаарлалтгүй зорчих автобусны улсын дугаарыг албан бичгээр Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний Удирдлагын төвд цахимаар хүргүүлнэ.

Хоёр. Бүрдүүлэх баримт бичиг

2.1. Автотээврийн хэрэгсэл болон жолоочийг бүртгэлийн санд шинээр бүртгэхдээ дараахь баримт бичгийг үндэслэнэ. Үүнд:

2.1.1. Хүүхдийн болон ажилчдын автобусыг чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээгээр улсын дугаарын хязгаарлалтгүйгээр зорчуулах тухай албан хүсэлт;

2.1.2. Тээвэрлэгчтэй хийсэн хүүхэд болон ажилчид тээвэрлэх гэрээний хуулбар;

2.1.3. Жолоочийн болон мэргэшсэн жолоочийн үнэмлэхний хуулбар;

2.1.4 Автотээврийн хэрэгслийн гэрчилгээ болон жолоочийн хариуцлагын даатгалын гэрээний хуулбар;

2.1.5 “Хүүхдийн болон ажилчдын их багтаамжийн автобусны хоёр хажуу тал болон урд, хойд талд 2200 мм х 180 мм хэмжээтэй шар дэвсгэр дээр “Монгол цагаан толгой дармал үсэг” MNS 4333:1996 стандартын дагуу үсгийн хэмжээ 100 мм х 50 мм /Arial font/ хар хөх өнгөөр хийсэн “ХҮҮХДИЙН АВТОБУС”, “АЖИЛЧДЫН АВТОБУС”, ажилчдын дунд болон бага багтаамжийн автобусны хоёр хажуу талд 2200 мм х 180 мм хэмжээтэй шар дэвсгэр дээр үсгийн хэмжээ 100 мм х 50 мм, урд хойд талд 1600 мм х 130 мм хэмжээтэй шар дэвсгэр дээр үсгийн хэмжээ 72 мм х 36 мм хар хөх өнгөөр хийсэн “АЖИЛЧДЫН АВТОБУС” бичээсийг нийтэд ил тод харагдахаар нааж, 4 талаас авсан фото зураг”;

2.1.6 Үйилчилгээний тогтоосон замнал, цагийн хуваарь;

Гурав. Автобусанд тавигдах шаардлага

3.1. Автобус нь “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2001, “Хүүхэд тээвэрлэх автобус. Автобус ба үйлчилгээнд тавих шаардлага” MNS 6440:2014 стандартын үзүүлэлт, шаардлагыг бүрэн хангасан байна.

3.2. Автобусны 2 хажуу талд аж ахуйн нэгж, байгууллагын нэр таних тэмдгийг /лого/ 400 мм х 400 мм хэмжээтэй хийж байршуулсан байна.

3.3. Хүүхдийн болон ажилчдын автобус нь Нийтийн Тээврийн үйлчилгээний газрын техникийн хяналтын үзлэгийн төвд техникийн хяналтын үзлэг, оношилгоонд орж тэнцсэн байна.

Дөрөв. Тээвэрлэлтийн үйлчилгээнд тавих шаардлага

4.1 Тээвэрлүүлэгч нь тээвэрлэгчийн үйл ажиллагаанд гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу даалгаврын хуудас олгож, хяналт тавьж ажиллана.

4.2 Тээвэрлүүлэгч нь тээвэрлэлтийн мэдээг тогтоосон үзүүлэлт, загвараар Нийтийн Тээврийн үйлчилгээний газарт улирал бүрийн эхний 7 хоногт багтаан гаргаж ирүүлнэ.

4.3 Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Автотээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулах давтамж, оношилгооны төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 213 дугаар тогтоолын дагуу Нийтийн тээврийн үйлчилгээний газрын Техникийн хяналтын үзлэгийн төвийн автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт жилд 2 удаа хамрагдана.

4.4 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын бүртгэлийн санд бүртгэлгүй жолооч болон автотээврийн хэрэгслээр хүүхэд болон ажилчид тээвэрлэхийг хориглоно.

Тав. Жолооч болон автобусыг бүртгэхээс татгалзах, бүртгэлийн сангаас хасах

5.1 Дараахь тохиолдолд тээврийн хэрэгсэл болон жолоочийг бүртгэхээс татгалзана.

5.1.1 Хүсэлт гаргагч нь энэ журмын 2 дах хэсэгт заасан баримт бичгийг бүрдүүлээгүй буюу хуурамчаар бүрдүүлсэн;

5.1.2 Автобус нь энэ журмын 3 дах хэсэгт заасан шаардлагыг хангаагүй;

5.2 Дараах тохиолдолд бүртгэлийн сангаас хасч, чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээгээр улсын дугаарын хязгаарлалтгүй зорчих жагсаалтаас хасна.

5.2.1 Хүүхдийн автобус нь “Хүүхэд тээвэрлэх автобус. Автобус ба үйлчилгээнд тавих шаардлага” MNS 6440:2014 стандартын 5.1.3-д заасны дагуу үйлдвэрлэгдсэнээс хойш 12-оос дээш жил ашигласан;

5.2.2 Техникийн хяналтын хавар, намрын үзлэгт хуваарьт хугацаанд давтан орж тэнцээгүй, тээврийн хэрэгслийн техникийн болон хэрэглээний стандартын үзүүлэлт, шаардлага “хангахгүй” дүгнэлт гарсан, эсхүл огт ороогүйг тодорхойлсон техникийн хяналтын үзлэгийн төвийн мэдээ, “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 5012:2011 стандартын 7.4 дэх заалтын дагуу насжилтаар хасагдах тээврийн хэрэгслийг тус газрын даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн;

5.2.3 Тээвэрлэлтэд тэнцэхгүй тухай Автотээврийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт;

5.2.4 Бүртгэлээс хасуулах тухай тээвэрлүүлэгч нь хүсэлт гаргасан;

Зургаа. Хяналт тавих болон журам зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх

6.1 Журмын хэрэгжилтэд Нийтийн тээврийн үйлчилгээний газар, Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний удирдлагын төв болон Тээврийн цагдаагийн албаны эрх бүхий албан тушаалтан хяналт тавьж ажиллана.

6.2 Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцно.

6.3 Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд гэмт хэргийн шинжгүй бол Зөрчлийн тухай хуулийн дагуу эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулна.

Нийтийн тээврийн үйлчилгээний газрын
даргын 2020 оны ... сарын ...-ны өдрийн
... дугаар тушаалын гуравдугаар хавсралт

САНАМЖ

Ажлаарын автобусны үйлчилгээнд дараах шаардлагыг
мөрдөж ажлаахыг жолооч танд сануулж байна.

- Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн гэрээгээр тогтоосон замнал, зогсоол болон цагийн хуваарийн дагуу тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, автобусны хурдыг цагт 50 км-ээс хэтрүүлэхгүйгээр хөдөлгөөнд оролцоно.
- Ажилчид тээвэрлэх тээврийн хэрэгсэл дотор замналын зураг болон бусад санамжуудыг зохих стандартын дагуу бичиж байрлуулсан байна.
- Хөдөлгөөн эхлэхийн өмнө ажилчдад зөв суух, хамгаалах бүс бүслэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг сахих зааварчилгааг өгнө.
- Жолооч нь үйлчилгээ эхэлсэн, дууссан цаг болон үйлчилгээний явцын мэдээллийг цаг тухай бүр тээвэрчүүдэд мэдэгдэж замын хуудсанд тэмдэглэгээ хийлгэнэ.
- Замын хөдөлгөөнд оролцохын өмнө автобусны техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан байна.
- Нийтийн тээврийн үйлчилгээний газрын бүртгэлийн санд бүртгэлгүй жолооч болон автотээврийн хэрэгслээр ажилчид тээвэрлэхийг хориглоно.
- Тээвэрлэгч нь ажилчдыг тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлага хангасан зорилдлын тээврийн хэрэгслээр тээвэрлээгүй бол Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хүүдийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

ЗӨВШӨӨГӨЛ АЖИЛЧДЫН АВТОБУС

ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

20 ОНЫ -р сарын -с

20 ОНЫ -р сарын

МАРК
АВТОБУСНЫ
ӨНГӨ

УЛСЫН ДУГААР



НИЙТИЙН ТЭЭВРИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР



ТЭЭВРИЙН ЦАГДААГИЙН
АЛБА

САГНАМЖ

Хүүхдийн автобусны үйлчилгээнд дараах шаардлагыг


мөрдөж ажлахаар жолооч танд сануулж байна.

- Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн гэрээгээр тогтоосон замнал, зогсоол болон цагийн хуваарийн дагуу тээвэрлэлтийг гүйцэтгэнэ
- Замьт хөдөлгөөний аюулгүй байлыг хангаж, автобусны хурдыг цагт 50 км-ээс хэтрүүлэхгүйгээр хөдөлгөөнд оролцоно.
- Тээвэрлэлтийн явцад сурагчдад зөвлөмж, зааварчилгаа өгөх, хяналт тавих, хүүхдэд туслах үүрэгтэй насанд хүрсэн нэг хүн ажиллана.
- Хүүхэд тээвэрлэх тээврийн хэрэгсэл дотор замналын зураг болон бусад шаардлагатай хуудсыг тохик стандартын дагуу бичиж байрлуулсан байна.
- Автобусар зөвхөн хүүхэд тээвэрлэнэ.
- Хөдөлгөөн эхлэхийн өмнө хүүхдэд зөв суух, хамгаалах бус бүслэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг сахих зааварчилгааг өгнө.
- Автобус бүрэн зогссоны дараа хүүхдүүдийг буулгаж, суулгаж халалга гүйцэд халсны дараа хөдөлгөөнийг эхлүүлнэ.
- Жолооч нь үйлчилгээ эхлэхэд, дууссан цаг болон үйлчилгээний явцын мэдээллийг цаг тухай бүр тээвэрлүүлэгчид мэдэгдэж замын хуудсанд тэмдэглэгээ хийлгэнэ.
- Замын хөдөлгөөнд оролцохын өмнө автобусны техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан байна.
- Нийтийн тээврийн үйлчилгээний газрын бүртгэлийн санд бүртгэлгүй жолооч болон автогээррийн хэрэгсэлээр хүүхэд тээвэрлэхийг хориглоно.
- Тээвэрлэгч нь хүүхдийг тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлага хангасны зорилгоор тээврийн хэрэгсэлээр хүүхдийн тээвэрлэлтгүй оох Зөрхийн тухай Хуулийн тавих нэгдүгээр тэнцэх дэххэ зэрэг Төлөөлөгчид Хуулийн этгээлийг нэг мянга таван хүн зэргээр төлөр Хүүхдийн тээврийн нэг шийтгэл оногдуулна. нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулна.

МОНГОЛ УЛСЫН MNS 6440 : 2014 "ХҮҮХЭД ТЭЭВЭРЛЭХ АВТОБУС БА ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ ШААРДЛАГА" СТАНДАРТЫН ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БОЛНО.

НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗАР

Нийтийн тээврийн үйлчилгээний газрын даргын 2020 оны ... дүгээр сарын ...-ны ... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ЗӨВШӨӨРӨЛ ХҮҮХДИЙН АВТОБУС

ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

20 ОНЫ -р сарын -с

20 ОНЫ -р сарын

МАРК
АВТОБУСНЫ
ӨНГӨ

УЛСЫН ДУГААР

НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗАР
ТЭЭВРИЙН ЦАГДААГИЙН АЛБА

